



УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА
САНДАГИЙН БЯМБАЦОГТ
ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Лхагвасүрэнгийн СОРОНЗОНБОЛД

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-15-03, Факс: 32-70-16
E-mail: soronzonbold@parliament.mn
http://www.parliament.mn

2026.05.21 № 412-03/5750
танай _____-ны № _____-т

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх
тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин зургаадугаар зүйлийн 1 дэх хэсэг, Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Хууль тогтоомжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан бүрэн эрхийнхээ хүрээнд Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг дагалдах бусад хуулийн төслийн хамт санаачлан боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын Байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж өгнө үү.

Хавсралт 3.7 хуудастай

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ
ХУРЛЫН ГИШҮҮН



Л.СОРОНЗОНБОЛД

М.БАДАМСҮРЭН

Ш.БЯМБАСҮРЭН

Г.ГАНБААТАР

М.ГАНХҮЛЭГ

Б.ДЭЛГЭРСАЙХАН

Ц.ИДЭРБАТ

0000132

Л.МӨНХБАЯСГАЛАН

Ц.МӨНХБАТ

Н.НАРАНБААТАР

У.ОТГОНБАЯР

Р.СЭДДОРЖ

Р.ЭРДЭНЭБҮРЭН



УЛСЫН ИХ ХУРЛЫН ЕРӨНХИЙ
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
Л.ӨЛЗИЙСАЙХАН ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Лхагвасүрэнгийн СОРОНЗОНБОЛД

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-15-03, Факс: 32-70-16
E-mail: soronzonbold@parliament.mn
http://www.parliament.mn

2026.03.27 № УИХ-03/3077
танай _____-ны № _____-т

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх
тов тогтоолгох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин зургаадугаар дугаар зүйл, Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, 36 дугаар зүйлийн 36.1 дэх хэсэгт заасан бүрэн эрхийнхээ дагуу Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэн, Ш.Бямбасүрэн, Г.Ганбаатар, М.Ганхүлэг, Б.Дэлгэрсайхан, Ц.Идэрбат, Л.Мөнхбаясгалан, Ц.Мөнхбат, Н.Наранбаатар, У.Отгонбаяр, Р.Сэддорж, Р.Эрдэнэбүрэн, нарын хамт Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг дагалдах бусад хуулийн төслийн хамт санаачлан боловсрууллаа.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 40 дүгээр зүйлд заасны дагуу хянан үзэж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх тов тогтоож өгнө үү.

Хуулийн төсөл, үзэл баримтлал, танилцуулга болон холбогдох материалыг хавсаргав.

Хавсралт..... хуудастай

УЛСЫН ИХ
ХУРЛЫН ГИШҮҮН



Л.СОРОНЗОНБОЛД

0000106



УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
М.БАДАМСҮРЭН НАР ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР**

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

2026.03.12 № ХЭГ/826
танай _____-ны № _____-т

**Хуралдааны тэмдэглэл
хүргүүлэх тухай**

Та бүхний санаачлан боловсруулсан Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцсэн тэмдэглэлийг үүгээр хүргүүлж байна.

Хавсралт 2 хуудастай.

Хүндэтгэсэн,

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА



С.БЯМБАЦОГТ

000265003732

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

Монгол Улсын Засгийн газрын 2026 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн 8 дугаар хуралдааны тэмдэглэлд:

“8.ХЭЛЭЛЦСЭН нь: Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэн нараас санаачлан боловсруулсан Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд Засгийн газраас өгөх санал, дүгнэлт

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэн нараас санаачлан боловсруулсан Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцээд, дараах үндэслэлээр дэмжих боломжгүй саналыг хууль санаачлагч нарт уламжлахаар тогтов:

1.Газрын тос, байгалийн хийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг тухайн аймаг, нийслэл, сум, дүүргийн төсөвт шууд хуваарилах нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5 дахь заалтад заасан “төсвийн удирдлагыг хэрэгжүүлэхдээ үндэсний баялгийг хүн ам, нийгмийн бүлэг болон өнөө ба хойч үеийнхэндээ шударга, тэнцвэртэй хуваарилах” зарчимтай нийцэхгүй байх бөгөөд орлогын дийлэнх хэсэг ашигт малтмал, газрын тос олборлож байгаа цөөн тооны аймаг, сумдад ногдох, орлогын тэгш бус хуваарилалт үүсэх үр дагавартай байна.

Иймд газрын тос, байгалийн хийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг улсын хэмжээнд бүс нутаг, иргэн бүрд тэгш хүртээмжтэй хуваарилах зарчмыг баримтлан Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаар дамжуулан тухайн аймгийн төсөвт хуваарилах нь зүйтэй;

2.Газрын тосны тухай хуулийн төсөлд нөөц ашигласны төлбөрийн 35 хувийг Үндэсний баялгийн санд, Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд газрын тос, байгалийн хийн нөөц ашигласны төлбөрийн орлогын 25 хувийг Ирээдүйн өв санд тус тус хуваарилахаар тусгасныг Монгол Улсын Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Байгалийн баялгийг ашиглах төрийн бодлого нь урт хугацааны хөгжлийн бодлогод тулгуурлаж, одоо ба ирээдүй үеийн иргэн бүрд эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг нь баталгаажуулах, газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлж тэгш, шударга хүртээхэд чиглэнэ” гэж заасантай нийцүүлэх;

3.Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Бүсчилсэн хөгжлийн удирдлага, зохицуулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөлд тусгасан Бүсийн хөгжлийн сан нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.28 дахь заалтад заасан орон нутгийн хөгжлийг дэмжих, бүс нутгийн хөгжлийн тэнцвэртэй байдлыг хангах зорилго бүхий Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан, мөн Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.3 дахь заалтад заасан газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг одоо ба ирээдүй үеийн иргэн бүрд тэгш, шударга хүртээх зорилгоор Монгол Улсын урт, дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт туссан хөгжлийн төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхэд дэмжлэг

үзүүлэх зориулалт бүхий Хөгжлийн сантай адил зориулалт, зорилготой байх тул Бүсийн хөгжлийн сан байгуулах шаардлагагүй;

4.Хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуульд заасан хуулийн төслийн бүтэц, хэлбэрт тавигдах шаардлага, мөн хуулийн төслийн үр нөлөө, зардлын тооцооны тайлан нь хуульд заасан шаардлагыг тус тус хангаагүй, төсөвт үзүүлэх нөлөөллийн талаарх тооцоо, судалгааг хийгээгүй байна.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

**БАТЛАВ.МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ГИШҮҮН**

Л.СОРОНЗОНБОЛД

2025 оны 06 дугаар сарын 09 -ны өдөр

**ГАЗРЫН ТОСНЫ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ
ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг.Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

1.1 Хууль зүйн үндэслэл

Монгол Улсын Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн нийтийн өмч мөн, “Байгалийн баялгийг ашиглах төрийн бодлого нь урт хугацааны хөгжлийн бодлогод тулгуурлаж, одоо ба ирээдүй үеийн иргэн бүрд эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг нь баталгаажуулах, газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлж тэгш, шударга хүртээхэд чиглэнэ” гэж Арван зургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт Монгол Улсын иргэн нь “Эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй” байхаар заасан.

Монгол Улсын Засгийн газраас Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг өргөн мэдүүлснийг Улсын Их Хурал хэлэлцэн 2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр баталсан. Энэхүү хуульд газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг төвлөрүүлэх, үр ашигтай хөрөнгө оруулалт хийх, одоо ба ирээдүй үеийн иргэн бүрд тэгш, шударга хуваарилах, хуримтлуулах төрөлжсөн сангаас бүрдэх тогтолцоог Үндэсний баялгийн сан гэж тодорхойлсон.

Түүнчлэн дээрх Үндэсний баялгийн төрөлжсөн сангуудад хатуу ашигт малтмал, цацраг идэвхт ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, уул уурхайн олборлолт, ашигт малтмалын боловсруулах салбарын хуулийн этгээдийн төрийн эзэмшилд ногдох ногдол ашгийг хуваарилахтай холбоотой харилцааг зохицуулахаар байна.

Харин газрын хэвлийн баялаг болох газрын тос, байгалийн хийн нөөц ашигласны төлбөрийг улсын төсөв, Үндэсний баялгийн сангийн төрөлжсөн сан, Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайг харьяалах бүс, аймаг, сумын төсөвт хэрхэн хуваарилах, мөн газрын тос, байгалийн хий олборлох, боловсруулах салбарын төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд дэх төрийн эзэмшлийн ногдол ашгийг баялгийн санд төвлөрүүлэхтэй холбоотой харилцааг Үндэсний баялгийн сангийн тухай хуульд тусгаагүй байна.

1.2 Практик шаардлага

Байгалийн баялгийг олборлох ашиглах үйл явц нь экологийн тэнцвэрт байдал төдийгүй тухайн бүс нутагт амьдарч буй иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхэд тодорхой хэмжээний сөрөг нөлөө үзүүлдэг тул манай улс Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт “эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй;” хэмээн тусгаж, энэхүү иргэдийн эрхийг баталгаажуулж өгсөн.

Энэхүү эрх нь “эрүүл орчинд амьдрах эрх”, “аюулгүй орчинд амьдрах эрх”, “орчны бохирдлоос хамгаалуулах эрх”, “байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрх” гэсэн дөрвөн эрхийг багтаасан цогц ойлголт төдийгүй эрүүл, аюулгүй орчин нь дан ганц хүн бус, бусад амьд амьтан, ургамалд ч хамаарах өргөн хүрээтэй ойлголт төдийгүй хүмүүс өдөр тутмын амьдралдаа амь бие, эрүүл мэндийн хувьд аливаа сөрөг нөлөөлөлд өртөхгүй байх, түүнээс ангид байх тухай ойлголтыг агуулдаг.

Мөн олон улсын байгууллагын судалгааны дүгнэлт зөвлөмжүүдэд ч уул уурхайн олборлолтын бүс нутагт амьдарч буй иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг хамгаалах, бэхжүүлэхэд хөрөнгө хуваарилах ёстойг харуулдаг. Тухайлбал, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн сангаас санаачлан 2017 оны 4 дүгээр сард “Уул уурхайгаас үүдсэн шилжилт хөдөлгөөн, хүүхдэд үзүүлэх нөлөөлөл” сэдвээр судалгаа хийж, зөвлөмж гаргасан байна. Тус зөвлөмжид “..,Уул уурхайн үйл ажиллагаа нь алслагдсан хөдөө орон нутагт хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, зам тээвэр, ус ба цахилгаан зэрэг дэд бүтцийг хөгжүүлэх, уул уурхайн ашиг орлого, татварын орлогыг дахин хуваарилах замаар улсын төсвийн хуваарилалт болон хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, уул уурхайн компаниуд нийгмийн хариуцлагын төслүүд хэрэгжүүлэх зэрэг олон эерэг үр нөлөөг орон нутагт авчрах боломжтой. Гэвч уул уурхайн үйл ажиллагаа нь нүүлгэн шилжүүлэлт, соёлын өөрчлөлтүүд, замын хөдөлгөөний ачаалал, тоосжилт, дуу чимээний бохирдол үүсгэх зэргээр иргэдийн аж амьдрал, эрүүл мэнд, аюулгүй орчинд амьдрах эрхэд нь сөргөөр нөлөөлдөг. Түүнчлэн тухайн орон нутгийн хүн амын өсөлтөөс үүдэн нийгмийн дэд бүтэц болон нийгмийн үйлчилгээнд нэмэлт ачаалал үүсэх зэрэг сөрөг үр дагавар үүсгэх боломжтой” талаар дурджээ.

Дээрх зөвлөмжид уул уурхайн салбар нь байгаль орчныг бохирдуулах, тухайн бүс нутгийн иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хөндөх, уламжлалт нүүдлийн аж ахуйн суурь болох бэлчээрийн газаргүй болох, мал, амьтны оршин байх нөхцөлийг дордуулах зэрэг асуудалтулгардаг тул анхаарах шаардлагатайг харуулж байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна” гэж заасан байдаг.

Мөн иргэний болон улс төрийн эрх буюу шүүхийн албадлагаар сэргээх боломжтой хүний үндсэн эрхийг негатив эрх, харин төрийн зүгээс тухайн эрхийг эдлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх замаар хэрэгжилтийг нь хангах эрхэд эдийн засаг, нийгэм, соёлын эрхийг хамааруулдаг. Тэгвэл Монгол Улсын Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт “эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг баталгаажуулах” хэмээн тусгасан нь энэхүү эрх нь өөрөө хэрэгжих шинжгүй эрх бөгөөд одоо ба ирээдүй үеийн иргэн бүрт эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг баталгаажуулахын тулд төрөөс эрх зүйн орчныг бүрдүүлэх учиртай.

Яагаад гэвэл, олон улсад байгалийн баялгийн олборлолт явагдаж буй бүс нутгийн иргэд, байгаль орчин, нийгэмд үзүүлж буй сөрөг нөлөөллийг хамгийн бага байлгах, тэдний амьжиргааг дэмжих, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээхтэй холбогдсон асуудлыг илүү анхаарах бодлого хэрэгжүүлдэг бөгөөд тус бүс нутагт чиглэсэн арга хэмжээг тусгайлан авч хэрэгжүүлдэг.

Тодруулбал, байгалийн баялгийн нөөцийг ашигласны үндсэн дээр бий болох орлого, түүний үр өгөөжийг одоо ба ирээдүй үеийн иргэн бүрт олгохоос гадна уул уурхайн үйл ажиллагаанаас төвлөрүүлсэн орлогын тодорхой хувийг олборлолтын сөрөг нөлөөлөлд өртөж буй тухайн бүс нутагт нь хуваарилах байдлаар шударга ёсны зарчмыг хангах хэрэгцээ шаардлага бий болоод байна.

Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 он үйл ажиллагааны хөтөлбөрийн бүсчилсэн хөгжлийн бодлогод “Бүс нутагт амьдрахад таатай нөхцөлийг бий болгох, хот, хөдөөгийн тэнцвэрийг хангах бүсчилсэн хөгжлийн бодлогыг хэрэгжүүлж, иргэдэд таатай, эрүүл, аюулгүй, байгаль орчинд ээлтэй дэд бүтэц бүхий хотуудыг хөгжүүлнэ” гэж заасан.

Бүсчилсэн хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхэд газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг тухайн бүс, орон нутагт хуваарилах байдлаар бүс, орон нутгийн хөгжлийн тэнцвэртэй байдлыг хангах, бүс нутгийн чанартай болон бүсийн хэлэлцээрээр тохиролцсон тэргүүлэх ач холбогдол бүхий хөгжлийн төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх байдлаар тухайн бүс, орон нутгийн эдийн засгийн чадавхыг дээшлүүлж, цаашлаад бие даан хөгжих боломжийг бүрдүүлж, үйл ажиллагааг тогтворжуулах, энэ чиглэлээр эрх зүйн орчныг бүрдүүлэх шаардлагатай байна.

Дээрх хууль зүйн болон практик хэрэгцээ шаардлагыг үндэслэн газрын хэвлийн баялаг болох газрын тос, байгалийн хийн нөөц ашигласны төлбөрийг улсын төсөв, Үндэсний баялгийн төрөлжсөн сангууд, Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан, газрын тосны ашиглалтын нөлөөлөлд өртөж буй тухайн бүс, аймаг, сумдын төсөвт хуваарилах, мөн газрын тос, байгалийн хий олборлох, боловсруулах салбарын төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд дэх төрийн эзэмшлийн хувьд ногдох ногдол ашгийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлэх энэ төрлийн харилцааг зохицуулахаар Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсрууллаа.

Хоёр.Хууль тогтоомжийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ:

Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл хоёр зүйлтэй байхаар боловсруулна.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлд дараах зохицуулалтыг тусгана. Үүнд:

Газрын тос, байгалийн хийн нөөц ашигласны төлбөрийг хуваарилахдаа улсын төсөв, Үндэсний баялгийн төрөлжсөн сан, Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан, Бүсийн хөгжлийн сан, аймаг, сумын орон нутгийн төсөвт тэгш, хүртээмжгэй хуваарилах зохицуулалтыг тусгасан.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлд уг өөрчлөлтийг дагаж мөрдөх журмын зохицуулалтыг тусгана.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар:

Газрын хэвлийн баялаг болох газрын тос, байгалийн хийн нөөц ашигласны төлбөрийн тодорхой хувийг Үндэсний баялгийн төрөлжсөн сан, улс, орон нутгийн төсөв, Орон нутгийн хөгжлийн нэгдсэн болон Бүсийн хөгжлийн сангуудад хуваарилах эрх зүйн орчин бүрдэнэ.

Газрын тос, байгалийн хий олборлох, боловсруулах салбарын төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд дэх төрийн эзэмшлийн ногдох ногдол ашгийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлнэ.

Газрын хэвлийн баялаг газрын тос, байгалийн хийг олборлох, ашиглах явцад сөрөг нөлөөлөлд өртөж буй тухайн бүс, орон нутгийн хүн амын эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах нөхцөл сайжирна.

Дөрөв.Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, шинэчлэн найруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн тухай санал:

Энэхүү хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын нэгдэн орсон Олон улсын гэрээ, конвенц болон бусад хууль тогтоомжид нийцсэн бөгөөд Байгалийн баялгийг ашиглах төрийн бодлого нь урт хугацааны хөгжлийн бодлогод тулгуурлаж, одоо ба ирээдүй үеийн иргэн бүрд энэхүү газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг тэгш, шударга хүртээх асуудлыг илүү боловсронгуй болгоно.

Энэхүү хуулийн төсөлтэй холбогдуулан Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Татварын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай, Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулна.

ГАЗРЫН ТОСНЫ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн нийтийн өмч мөн. Байгалийн баялгийг ашиглах төрийн бодлого нь урт хугацааны хөгжлийн бодлогод тулгуурлаж, одоо ба ирээдүй үеийн иргэн бүрд эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг нь баталгаажуулах, газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлж тэгш, шударга хүртээхэд чиглэнэ. Иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийнхээ хүрээнд газрын хэвлийн баялгийг ашигласнаар байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн талаар мэдэх эрхтэй. Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашиглахдаа байгалийн баялаг ард түмний мэдэлд байх зарчимд нийцүүлэн түүний үр өгөөжийн дийлэнх нь ард түмэнд ногдож байх эрх зүйн үндсийг хуулиар тогтооно” гэж заасан.

Үндсэн хуулийн энэ суурь зохицуулалт, агуулгын хүрээнд Газрын тосны тухай хуулийг 1991 онд анх баталж, 2014 онд шинэчлэн найруулсан. Уг хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсэгт “Гэрээлэгч газрын тосны хайгуулын болон ашиглалтын үед тусгай зөвшөөрлийн төлбөрийг жил бүр төлнө.” 30.6 дахь хэсэгт “Тусгай зөвшөөрлийн төлбөрийн 10 хувийг тухайн тусгай зөвшөөрлийн талбайг харьяалах сум, дүүргийн төсөвт, 20 хувийг аймаг, нийслэлийн төсөвт, 70 хувийг улсын төсөвт тус тус хуваарилна”, 31 дүгээр зүйлийн 31.3 дэх хэсэгт “Нөөц ашигласны төлбөрийн 30 хувийг орон нутгийн хөгжлийн нэгдсэн санд, 70 хувийг улсын төсөвт тус тус төвлөрүүлнэ” хэмээн зохицуулсан.

Мөн Монгол Улсын Засгийн газраас Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төслийг боловсруулан өргөн мэдүүлснийг Улсын Их Хурал хэлэлцэн 2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр баталсан. Газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг төвлөрүүлэх, үр ашигтай хөрөнгө оруулалт хийх, одоо ба ирээдүй үеийн иргэн бүрд тэгш, шударга хуваарилах, хуримтлуулах төрөлжсөн сангаас бүрдэх тогтолцоог Үндэсний баялгийн сан гэж тодорхойлсон байх бөгөөд төрөлжсөн сангуудад хатуу ашигт малтмал, цацраг идэвхт ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, уул уурхайн олборлолт, ашигт малтмалын боловсруулах салбарын хуулийн этгээдийн төрийн эзэмшилд ногдох ногдол ашгийг хуваарилахтай холбоотой харилцааг зохицуулахаар уг хуульд тусгажээ.

Харин газрын хэвлийн баялаг болох газрын тос, байгалийн хийн нөөц ашигласны төлбөрийг улсын төсөв, Үндэсний баялгийн сангийн төрөлжсөн сан, Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайг харьяалах бүс, аймаг, сумын төсөвт хэрхэн хуваарилах, мөн газрын тос, байгалийн хий олборлох, боловсруулах салбарын төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд дэх төрийн эзэмшлийн ногдол ашгийг баялгийн санд төвлөрүүлэхтэй холбоотой харилцааг тусгаагүй орхигдуулсан байна.

Түүнчлэн байгалийн баялгийг олборлох ашиглах үйл явц нь экологийн тэнцвэрт байдал төдийгүй тухайн бүс нутагт амьдарч буй иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхэд тодорхой хэмжээний сөрөг нөлөө үзүүлдэг тул манай улс Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт “эрүүл, аюулгүй орчинд амьдрах,

орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй;" хэмээн тусгаж, энэхүү иргэдийн эрхийг баталгаажуулж өгсөн.

Мөн олон улсын байгууллагын судалгааны дүгнэлт зөвлөмжүүдэд ч уул уурхайн олборлолтын бүс нутагт амьдарч буй иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг хамгаалах, бэхжүүлэхэд хөрөнгө хуваарилах ёстойг харуулдаг. Тухайлбал, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн сангаас санаачлан 2017 оны 4 дүгээр сард "Уул уурхайгаас үүдсэн шилжилт хөдөлгөөн, хүүхдэд үзүүлэх нөлөөлөл" сэдвээр судалгаа хийж, зөвлөмж гаргасан байна.

Тус зөвлөмжид "...Уул уурхайн үйл ажиллагаа нь алслагдсан хөдөө орон нутагт хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, зам тээвэр, ус ба цахилгаан зэрэг дэд бүтцийг хөгжүүлэх, уул уурхайн ашиг орлого, татварын орлогыг дахин хуваарилах замаар улсын төсвийн хуваарилалт болон хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, уул уурхайн компаниуд нийгмийн хариуцлагын төслүүд хэрэгжүүлэх зэрэг олон зэрэг үр нөлөөг орон нутагт авчрах боломжтой. Гэвч уул уурхайн үйл ажиллагаа нь нүүлгэн шилжүүлэлт, соёлын өөрчлөлтүүд, замын хөдөлгөөний ачаалал, тоосжилт, дуу чимээний бохирдол үүсгэх зэргээр иргэдийн аж амьдрал, эрүүл мэнд, аюулгүй орчинд амьдрах эрхэд нь сөргөөр нөлөөлдөг. Түүнчлэн тухайн орон нутгийн хүн амын өсөлтөөс үүдэн нийгмийн дэд бүтэц болон нийгмийн үйлчилгээнд нэмэлт ачаалал үүсэх зэрэг сөрөг үр дагавар үүсгэх боломжтой" талаар дурджээ.

Дээрх зөвлөмжид уул уурхайн салбар нь байгаль орчныг бохирдуулах, тухайн бүс нутгийн иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хөндөх, уламжлалт нүүдлийн аж ахуйн суурь болох бэлчээрийн газаргүй болох, мал, амьтны оршин байх нөхцөлийг дордуулах зэрэг асуудал үүсгэдэг тул анхаарах шаардлагатайг харуулж байна.

Мөн Монгол Улсын Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна" гэж заасан байдаг.

Түүнчлэн иргэний болон улс төрийн эрх буюу шүүхийн албадлагаар сэргээх боломжтой хүний үндсэн эрхийг негатив эрх, харин төрийн зүгээс тухайн эрхийг эдлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх замаар хэрэгжилтийг нь хангах эрхэд эдийн засаг, нийгэм, соёлын эрхийг хамааруулдаг. Тэгвэл Монгол Улсын Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт "эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг баталгаажуулах" хэмээн тусгасан нь энэхүү эрх нь өөрөө хэрэгжих шинжгүй эрх бөгөөд одоо ба ирээдүй үеийн иргэн бүрт эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг баталгаажуулахын тулд төрөөс эрх зүйн орчныг бий болгоно.

Учир нь олон улсад байгалийн баялгийн олборлолт явагдаж буй бүс нутгийн иргэд, байгаль орчин, нийгэмд үзүүлж буй сөрөг нөлөөллийг хамгийн бага байлгах, тэдний амьжиргааг нь дэмжих, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээхтэй холбогдсон асуудлыг илүү анхаарах хандлагатай бөгөөд тус бүс нутагт чиглэсэн арга хэмжээг тусгайлан авч хэрэгжүүлдэг.

Тодруулбал, байгалийн баялгийн нөөцийг ашигласны үндсэн дээр бий болох орлого, түүний үр өгөөжийг одоо ба ирээдүй үеийн иргэн бүрт олгохоос гадна уул уурхайн үйл ажиллагаанаас төвлөрүүлсэн орлогын тодорхой хувийг олборлолтын сөрөг нөлөөлөлд өртөж буй тухайн бүс нутагт нь хуваарилах байдлаар шударга ёсны зарчмыг хангах хэрэгцээ шаардлага бий болоод байна

Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 он үйл ажиллагааны хөтөлбөрийн бүсчилсэн хөгжлийн бодлогод “Бүс нутагт амьдрахад таатай нөхцөлийг бий болгох, хот, хөдөөгийн тэнцвэрийг хангах бүсчилсэн хөгжлийн бодлогыг хэрэгжүүлж, иргэдэд таатай, эрүүл, аюулгүй, байгаль орчинд ээлтэй дэд бүтэц бүхий хотуудыг хөгжүүлнэ” гэж заасан.

Бүсчилсэн хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхэд газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг тухайн бүс, орон нутагт хуваарилах байдлаар бүс, орон нутгийн хөгжлийн тэнцвэртэй байдлыг хангах, бүс нутгийн чанартай болон бүсийн хэлэлцээрээр тохиролцсон тэргүүлэх ач холбогдол бүхий хөгжлийн төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх байдлаар тухайн бүс, орон нутгийн эдийн засгийн чадавхийг дээшлүүлж, цаашлаад бие даан хөгжих боломжийг бүрдүүлж, үйл ажиллагааг тогтворжуулах, энэ чиглэлээр эрх зүйн орчинг бүрдүүлэх шаардлагатай байна.

Дээрх хууль зүйн болон практик хэрэгцээ шаардлагыг үндэслэн газрын хэвлийн баялаг болох газрын тос, байгалийн хийн нөөц ашигласны төлбөрийг Улсын төсөв, Үндэсний баялгийн төрөлжсөн сангууд, Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан, газрын тосны ашиглалтын нөлөөлөлд өртөж буй тухайн бүс, аймаг, сумдын төсөвт хуваарилах, мөн газрын тос, байгалийн хий олборлох, боловсруулах салбарын төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд дэх төрийн эзэмшлийн хувьд ногдох ногдол ашгийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлэх энэ төрлийн харилцааг зохицуулахаар Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон дагалдах бусад хуулийн төслийг боловсрууллаа.

ГАЗРЫН ТОСНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн нийтийн өмч мөн, “Байгалийн баялгийг ашиглах төрийн бодлого нь урт хугацааны хөгжлийн бодлогод тулгуурлаж, одоо ба ирээдүй үеийн иргэн бүрд эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг нь баталгаажуулах, газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлж тэгш, шударга хүртээхэд чиглэнэ” гэж Арван зургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт Монгол Улсын иргэн нь “Эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй” байхаар заасан.

Үндсэн хуульд заасан төрийн нийтийн өмч газрын хэвлийн баялаг болох газрын тос, байгалийн хийн нөөц ашигласны төлбөрийг Улсын төсөв, Үндэсний баялгийн төрөлжсөн сангууд, Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан, газрын тосны ашиглалтын нөлөөлөлд өртөж буй тухайн бүс, аймаг, сумдын төсөвт хуваарилах, мөн газрын тос, байгалийн хий олборлох, боловсруулах салбарын төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд дэх төрийн эзэмшлийн хувьд ногдох ногдол ашгийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулаагүй байна.

Иймд одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Газрын тосны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3 дахь хэсэгт заасан “Нөөц ашигласны төлбөрийн 30 хувийг орон нутгийн хөгжлийн нэгдсэн санд, 70 хувийг улсын төсөвт тус тус төвлөрүүлнэ” гэснийг газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлж тэгш, шударгаар хүртээхэд чиглэнэ гэсэн Монгол Улсын Үндсэн хуулийн суурь зарчимд нийцүүлж хуулийн төслийг дараах байдлаар боловсрууллаа.

Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслөөр 31.3 дахь хэсгийг “Нөөц ашигласны төлбөрийг Улсын төсөвт 25 хувь, Үндэсний баялгийн төрөлжсөн санд 35 хувь, Орон нутгийн хөгжлийн нэгдсэн санд 10 хувь, тухайн тусгай зөвшөөрлийн талбай байрлах Бүсийн хөгжлийн санд 10, тухайн тусгай зөвшөөрлийн талбай байрлах аймаг, нийслэлийн төсөвт 10 хувь, тухайн тусгай зөвшөөрлийн талбай байрлах сум, дүүргийн төсөвт 10 хувь” тус тус хуваарилахаар зохицуулсан хуулийн төслийг боловсруулсан бөгөөд дагалдах хуулийн төслөөр дараах 4 хуулийн төслийг боловсруулсан.

Дагалдах хуулиудын төслийн агуулгыг хуулийн төсөл тус бүрээр тодорхойлбол,

Нэг. Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг 4 зүйлтэй байхаар боловсруулсан.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлд: Үндэсний баялгийн төрөлжсөн санд газрын тос, байгалийн хийн нөөц ашигласны төлбөрийг төвлөрүүлэх болон газрын тос, байгалийн хий олборлох, боловсруулах салбарын төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд дэх төрийн эзэмших хувь, ногдол ашгийн хувь хэмжээг дараах байдлаар нэмэхээр тусгасан.

-Ирээдүйн өв санд Газрын тос, байгалийн хийн нөөц ашигласны төлбөрийн орлогын 25 хувь,

-Хуримтлалын санд Газрын тос, байгалийн хийн нөөц ашигласны төлбөрийн орлогын 5 хувь, Газрын тос, байгалийн хий олборлох, боловсруулах салбарын төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд дэх төрийн эзэмших хувьцаа 34 хувь хүртэлх бол түүний төрийн эзэмшилд ногдох бүх ногдол ашиг, Газрын тос, байгалийн хий олборлох, боловсруулах салбарын төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд дэх төрийн эзэмших хувьцаа 34 хувь ба түүнээс дээш бол түүний төрийн эзэмшлийн 34 хувьд ногдох ногдол ашгийг;

Хуулийн төслийн 2 дугаар зүйлд: Одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 12.4 дэх хэсгийн “Уул уурхайн олборлолт,” , 12.6 дахь хэсгийн “Уул уурхайн олборлолт,” гэсний дараа “газрын тос, байгалийн хий,” гэдгийг нэмэлтээр тусгаж өөрчлөн найруулахаар боловсруулсан.

Хуулийн төслийн 3 дугаар зүйлд: Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 11.1.3 дахь заалтыг өөрчлөн найруулсан.

-Хөгжлийн санд нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл ашигтай гарсан тохиолдолд гол нэр төрлийн эрдэс баялгийн үнэ тухайн жилийн төсөвт тооцсон тэнцвэржүүлсэн үнээс өндөр байснаас нэмэгдэж орох төсвийн орлогын 50 хувь, газрын тос, байгалийн хийн нөөц ашигласны төлбөрийн орлогын 5 хувиас тус тус бүрдэхээр тусгасан.

Хуулийн төслийн 4 дүгээр зүйлд: Энэхүү хуулийн төслийн хүчин төгөлдөр болох журмын зохицуулалтыг тусгасан.

Хоёр:Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 3 зүйлтэй байхаар дараах байдлаар боловсруулсан.

Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлд Төсвийн тухай хуулийн холбогдох заалтад дараах агуулгатай зүйл хэсэг, заалт нэмэх асуудлыг тусгасан. Үүнд:

1.Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлд Бүсийн хөгжлийн сан гэсэн тодорхойлолтыг нэмж, энэхүү сангийн эх үүсвэрийн асуудлыг 59 дүгээр зүйлийн 59.10 дахь хэсгээр зохицуулахаар,

2.Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 6 дугаар хэсэг “Аймаг, нийслэл болон улсын зэрэглэлтэй хотын төсвийн татварын орлогод хамаарах орлого”-д газрын тос, байгалийн хийн ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайг харьяалах сумын төсөвт тухайн аймгийн нутаг дэвсгэрээс төвлөрүүлсэн газрын тос, байгалийн хийн нөөц ашигласны төлбөрийн орлогын 10 хувийг,

3.Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 8 дугаар хэсэг “Сум, дүүрэг, орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны төсвийн татварын орлого”-д газрын тос, байгалийн хийн ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайг харьяалах сумын төсөвт тухайн сумын нутаг дэвсгэрээс төвлөрүүлсэн газрын тос, байгалийн хийн нөөц ашигласны төлбөрийн орлогын 10 хувь байхаар тус тус нэмсэн.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлд: Төсвийн тухай хуулийн 23.4.11, 59.1.5, 59.5 дахь хэсгүүдийг дараах байдлаар өөрчлөн найруулахаар тусгасан. Үүнд:

-Төсвийн тухай хуулийн 23.4.13 дахь заалт “газрын тосны нөөц ашигласны төлбөрийн 70 хувь;” гэснийг хуулийн төсөлд “Газрын тос, байгалийн хийн нөөц ашигласны төлбөрийн 25 хувь;” гэж,

-Төсвийн хуулийн 59.1.5 дахь заалт “газрын тосны нөөц ашигласны төлбөрийн орлогын 30 хувь.” гэснийг хуулийн төсөлд “Газрын тос, байгалийн хийн нөөц ашигласны төлбөрийн орлогын 10 хувь;” гэж,

-Төсвийн тухай хуулийн 59.5 дахь хэсэг “Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон Орон нутгийн хөгжлийн сангаас олгох шилжүүлгийг тооцох аргачлалыг Засгийн газар батална.” гэснийг хуулийн төсөлд “Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан, Бүсийн хөгжлийн сан болон Орон нутгийн хөгжлийн сангаас олгох шилжүүлгийг тооцох аргачлалыг Засгийн газар батална” гэж тус тус өөрчлөхөөр боловсруулсан.

Гурав:Бүсчилсэн хөгжлийн удирдлага, зохицуулалтын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 3 зүйлтэй.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлд: Бүс тус бүр бүс, орон нутгийн хөгжлийн тэнцвэртэй байдлыг хангах, бүс нутгийн чанартай болон Бүсийн хэлэлцээрээр тохиролцсон тэргүүлэх ач холбогдол бүхий хөгжлийн төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх зорилготой Бүсийн хөгжлийн сантай байх хуулийн зохицуулалтыг тусгасан бөгөөд 2 дугаар зүйлд Энэ хуулийг Газрын тосны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр тусгасан.

Дөрөв:Татварын ерөнхий хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг 2 зүйлтэй байхаар боловсруулсан.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлд: Газрын тосноос гадна байгалийн хийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг Татварын ерөнхий хуульд тусгаагүй байсныг нэмж зохицуулсан бөгөөд 2 дугаар зүйлээр энэхүү хуулийн хүчин төгөлдөр болох асуудлыг тусгасан болно.

Дээрх байдлаар газрын хэвлийн баялаг болох газрын тос, байгалийн хийн нөөц ашигласны төлбөрийг Үндэсний баялгийн сангийн төрөлжсөн сан, уул уурхайн олборлолтын улмаас сөрөг нөлөөлөлд өртөж буй ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбайг харьяалах бүс, аймаг, сумын төсөвт хэрхэн хуваарилах болон газрын тос, байгалийн хий олборлох, боловсруулах салбарын төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд дэх төрийн эзэмшлийн ногдол ашгийг баялгийн санд төвлөрүүлэх харилцааны эрх үндсийг бий болгосноор “...Байгалийн баялгийг ашиглах төрийн бодлого нь урт хугацааны хөгжлийн бодлогод тулгуурлаж, одоо ба ирээдүй үеийн иргэн бүрд эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг нь баталгаажуулах, газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлж тэгш, шударга хүртээхэд чиглэнэ” гэсэн Монгол Улсын Үндсэн хуулийн зургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан суурь зарчимд нийцэж байгаа болно.

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

ГАЗРЫН ТОСНЫ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Газрын тосны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай.

“31.3.Нөөц ашигласны төлбөрийн 25 хувийг улсын төсөвт, 35 хувийг Үндэсний баялгийн санд, 10 хувийг Орон нутгийн хөгжлийн нэгдсэн санд, 10 хувийг тухайн тусгай зөвшөөрлийн талбай байрлах Бүсийн хөгжлийн санд, 10 хувийг тухайн тусгай зөвшөөрлийн талбай байрлах аймаг, нийслэлийн төсөвт, 10 хувийг тухайн тусгай зөвшөөрлийн талбай байрлах сум, дүүргийн төсөвт тус тус хуваарилна.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг 20... оны ... дугаар сарын ... -ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

**ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Төсвийн тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах зүйл, хэсэг, заалт нэмсүгэй.

1/4 дүгээр зүйлийн 4.1.59 дэх заалт:

“4.1.59.”Бүсийн хөгжлийн сан” гэж бүс, орон нутгийн хөгжлийн тэнцвэртэй байдлыг хангах, бүс нутгийн чанартай болон бүсийн хэлэлцээрээр тохиролцсон тэргүүлэх ач холбогдол бүхий хөгжлийн төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх зорилгоор улсын төсөв, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас дахин хуваарилалт хийх хөрөнгийг;”

2/23 дугаар зүйлийн 23.6.13 дахь заалт:

“23.6.13.Газрын тос, байгалийн хийн ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайг харьяалах аймгийн төсөвт тухайн аймгийн нутаг дэвсгэрээс төвлөрүүлсэн газрын тос, байгалийн хийн нөөц ашигласны төлбөрийн орлогын 10 хувийг хуваарилна.”

3/23 дугаар зүйлийн 23.8.19 дэх заалт:

“23.8.19.Газрын тос, байгалийн хийн ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайг харьяалах сумын төсөвт тухайн сумын нутаг дэвсгэрээс төвлөрүүлсэн газрын тос, байгалийн хийн нөөц ашигласны төлбөрийн орлогын 10 хувийг хуваарилна.”

4/59 дүгээр зүйлийн 59.10 дахь хэсэг:

“59.10.Бүсийн хөгжлийн сантай байна:

59.10.1.Бүсийн хөгжлийн сан нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ:

59.10.1.1.газрын тос, байгалийн хийн ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайг харьяалах бүсийн аймгийн нутаг дэвсгэрээс төвлөрүүлэх газрын тосны болон байгалийн хийн нөөц ашигласны төлбөрийн орлогын 10 хувь;

59.10.1.2.бүс, орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор олгосон дотоодын төрийн бус байгууллагын болон гадаадын албан ёсны тусламж, хандив, дээд шатны байгууллагатай хамтран хэрэгжүүлж байгаа олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрөөс олгох урамшуулал, дэмжлэг.”

2 дугаар зүйл.Төсвийн тухай хуулийн дараах хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/23 дугаар зүйлийн 23.4.11 дэх заалт:

“23.4.11.газрын тос, байгалийн хийн нөөц ашигласны төлбөрийн 25 хувь;”

2/59 дугаар зүйлийн 59.1.5 дахь заалт:

“59.1.5.газрын тос, байгалийн хийн нөөц ашигласны төлбөрийн орлогын 10 хувь;”

3/59 дүгээр зүйлийн 59.5 дахь хэсэг:

“59.5.Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан, Бүсийн хөгжлийн сан болон Орон нутгийн хөгжлийн сангаас олгох шилжүүлгийг тооцох аргачлалыг Засгийн газар батална.”

3 дугаар зүйл.Төсвийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.7 дахь хэсгийн “мөн хуулийн 59.1.5-д заасан эх үүсвэрээс бүрдсэн орлогын 30 хувийг тухайн эх үүсвэрийн 1 ба түүнээс дээш хувийг бүрдүүлэх аймаг, улсын зэрэглэлтэй хотод тэнцүү хэмжээгээр” гэснийг хассугай.

4 дүгээр зүйл.Энэ хуулийг Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН УДИРДЛАГА, ЗОХИЦУУЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай хуулийн 16 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 16.3 дахь хэсэг нэмсүгэй:

“16.3. Бүс тус бүр бүс, орон нутгийн хөгжлийн тэнцвэртэй байдлыг хангах, бүс нутгийн чанартай болон Бүсийн хэлэлцээрээр тохиролцсон тэргүүлэх ач холбогдол бүхий хөгжлийн төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх зорилготой Бүсийн хөгжлийн сантай байна.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Татварын ерөнхий хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.36 дахь заалтын “газрын тосны” гэснийг “газрын тос, байгалийн хийн” гэж, 7 дугаар зүйлийн 7.2.11 дэх заалтын “газрын тосны нөөц ашигласны төлбөр” гэснийг “газрын тос, байгалийн хийн” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

ҮНДЭСНИЙ БАЯЛГИЙН САНГИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 11 дүгээр зүйлдийн 11.1 дэх хэсэгт доор дурдсан агуулгатай 11.1.1в, 11.1.2.д, 11.1.2.е, 11.1.2.ё дэд заалт тус тус нэмсүгэй:

“11.1.1.в.газрын тос, байгалийн хийн нөөц ашигласны төлбөрийн орлогын 25 хувь.

11.1.2.д.газрын тос, байгалийн хий олборлох, боловсруулах салбарын төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд дэх төрийн эзэмших хувьцаа 34 хувь хүртэлх бол түүний төрийн эзэмшилд ногдох бүх ногдол ашиг;

11.1.2.е.Газрын тос, байгалийн хий олборлох, боловсруулах салбарын төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд дэх төрийн эзэмших хувьцаа 34 хувь ба түүнээс дээш бол түүний төрийн эзэмшлийн 34 хувьд ногдох ногдол ашгийг;

11.1.2.ё.Газрын тос, байгалийн хийн нөөц ашигласны төлбөрийн орлогын 5 хувь;”

2 дугаар зүйл. Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.4 дэх хэсгийн “Уул уурхайн олборлолт,” гэсний дараа, 12.6 дахь хэсгийн “уул уурхайн олборлолт,” гэсний дараа “газрын тос, байгалийн хий,” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл. Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.3 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“11.1.3.Хөгжлийн сан дараах эх үүсвэрээс бүрдэнэ:

11.1.3.а.нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл ашигтай гарсан тохиолдолд гол нэр төрлийн эрдэс баялгийн үнэ тухайн жилийн төсөвт тооцсон тэнцвэржүүлсэн үнээс өндөр байснаас нэмэгдэж орох төсвийн орлогын 50 хувь;

11.1.3.б.газрын тос, байгалийн хийн нөөц ашигласны төлбөрийн орлогын 5 хувь.”

4 дүгээр зүйл. Энэ хуулийг Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.”

ГАЗРЫН ТОСНЫ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫГ УРЬДЧИЛАН ТАНДАН СУДАЛСАН ТАЙЛАН

Нэг. Асуудалд дүн шинжилгээ хийсэн байдал

Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсэгт заасны дагуу судалсан бөгөөд энэхүү хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын гэрээ, конвенц, бусад хууль тогтоомжид харшлаагүй нийцэж байгаа болно.

Хоёр. Асуудлыг үүсгэж буй учир шалтгаан

Монгол Улсын Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт: *“... Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн нийтийн өмч мөн...”* гэж заасан.

Мөн “Байгалийн баялгийг ашиглах төрийн бодлого нь урт хугацааны хөгжлийн бодлогод тулгуурлаж, одоо ба ирээдүй үеийн иргэн бүрт эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг нь баталгаажуулах, газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлж тэгш, шударга хүртээхэд чиглэнэ.

Иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийнхээ хүрээнд газрын хэвлийн баялгийг ашигласнаар байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн талаар мэдэх эрхтэй. Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашиглахдаа байгалийн баялаг ард түмний мэдэлд байх зарчимд нийцүүлэн түүний үр өгөөжийн дийлэнх нь ард түмэнд ногдож байх эрх зүйн үндсийг хуулиар тогтооно” гэж Үндсэн хуульд заасан. Үүний дагуу Монгол Улсын Засгийн газраас Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг өргөн мэдүүлснийг Улсын Их Хурал хэлэлцэн 2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр баталсан.

Дээрх хуульд заасан баялгийн төрөлжсөн сангуудад хатуу ашигт малтмал, цацраг идэвхт ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, уул уурхайн олборлолт, ашигт малтмалын боловсруулах салбарын хуулийн этгээдийн төрийн эзэмшилд ногдох ногдол ашгийг хуваарилах харилцааг зохицуулсан болно.

Газрын хэвлийн баялаг газрын тосыг ашиглах явцад тухайн орон нутгийн хүн амын эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хамгаалах, амьжиргааг нь дэмжих, байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг хамгийн бага байлгах, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээхэд шаардагдах төсөв, хөрөнгийг тухайн орон нутгийн хөгжлийн сан, орон нутгийн төсөвт хуваарилдаг олон улсын зарчмыг хэрэгжүүлж, энэ төрлийн харилцааг зохицуулж байгаа хууль тогтоомжид өөрчлөлт оруулах хэрэгцээ шаардлага үүссэн.

Түүнчлэн газрын тосны нөөц ашигласны төлбөр, мөн газрын тос, байгалийн хий олборлох, боловсруулах салбарын төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд дэх төрийн эзэмших хувьцаа 34 хувь ба түүнээс дээш бол түүний төрийн эзэмшлийн ногдох ногдол ашгийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлэх харилцааг хуулиар зохицуулаагүй орхигдуулсан тул энэ асуудлыг зохицуулах зайлшгүй шаардлага үүсээд байна.

Иймд Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсрууллаа. Дээр дурдсан шаардлагад үндэслэн одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Газрын тосны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3 дахь хэсэгт “Нөөц ашигласны төлбөрийн 30 хувийг орон нутгийн хөгжлийн нэгдсэн санд, 70 хувийг улсын төсөвт тус тус төвлөрүүлнэ” гэж заасан.

Боловсруулсан Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслөөр нөөц ашигласны төлбөрийн 10 хувийг тухайн тусгай зөвшөөрлийн талбай байрлах сум, дүүргийн төсөвт, 10 хувийг тухайн тусгай зөвшөөрлийн талбай байрлах аймаг, нийслэлийн төсөвт, 10 хувийг тухайн тусгай зөвшөөрлийн талбай байрлах Бүсийн хөгжлийн санд, 10 хувийг Орон нутгийн хөгжлийн нэгдсэн санд, 25 хувийг улсын төсөвт, 35 хувийг Үндэсний баялгийн санд тус тус хуваарилахаар тусгасан.

Түүнчлэн дээрх хуулийн төсөлтэй холбогдуулан Төсвийн тухай хууль, Үндэсний баялгийн сангийн тухай хууль, Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай хууль, Татварын ерөнхий хуульд тус тус нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулсан болно.

Гурав. Асуудлыг шийдвэрлэх зорилгыг тодорхойлсон байдал

Энэхүү төсөл нь байгалийн баялгийг ашиглах төрийн бодлого нь урт хугацааны хөгжлийн бодлогод тулгуурлаж, одоо ба ирээдүй үеийн иргэн бүрт эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг нь баталгаажуулах, газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлж тэгш, шударга хүртээх болон газрын тосны нөөц ашигласны төлбөр, Үндэсний баялгийн санд төвлөрүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулж асуудлыг шийдвэрлэх зорилгод нийцсэн болно.

Дөрөв. Асуудлыг зохицуулах хувилбарууд, тэдгээрийн зэрэг, сөрөг талыг харьцуулсан байдал

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал”-ын 5.1 дэх хэсэгт заасан зохицуулалтын хувилбарыг тогтоож, зэрэг болон сөрөг талыг нь харьцуулан судалсан.

Хувилбар	Зорилгод хүрэх байдал	Зардал, үр өгөөжийн харьцаа
Хууль тогтоомжид өөрчлөлт оруулах төсөл боловсруулах	Зорилгодоо хүрэх бүрэн боломжтой	Нэмэлт зардал шаардагдахгүй

Тав. Зохицуулалтын хувилбарын үр нөлөөг тандан судалсан байдал

Аргачлалын 6-д заасны дагуу сонгосон хувилбарын үр нөлөөг ерөнхий асуултуудад хариуцлах замаар дүгнэлтийг гаргалаа.

Хүснэгт 1: Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө

Үзүүлэх нөлөө	Үр	Холбогдох асуулт	Хариулт	Тайлбар
1.Хүний эрхийн суурь зарчмуудад нийцэж байгаа эсэх		1.1.Ялгаварлан гадуурхахгүй ба тэгш байх		
		1.1.1.Ялгаварлан гадуурхахыг хориглох эсэх	Үгүй	
		1.1.2.Ялгаварлан гадуурхсан буюу аль нэг бүлэгт давуу байдал үүсгэх эсэх	Үгүй	
		1.1.3.Тодорхой эмзэг бүлгийн нөхцөл байдлыг сайжруулах зорилгоор авч хэрэгжүүлэх арга хэмжээ бол олон улсын болон үндэсний хууль тогтоомжид заасан хүний эрхийн хэм хэмжээтэй нийцэж байгаа эсэх	Тийм	
		1.2.Оролцоог хангах		
		1.2.1.Зохицуулалтын хувилбарыг сонгохдоо оролцоог хангасан эсэх, ялангуяа эмзэг бүлэг, цөөнхийн оролцох боломжийг бүрдүүлсэн эсэх	Тийм	
		1.2.2.Зохицуулалтыг бий болгосноор эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа, эсхүл хөндөгдөж болзошгүй иргэдийг тодорхойлсон эсэх	Тийм	
		1.3.Хууль дээдлэх зарчим ба сайн		
		1.3.1.Зохицуулалтыг бий болгосноор хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хангах, хамгаалах явцад ахиц дэвшил гарах эсэх	Тийм	
		1.3.2.Зохицуулалтын хувилбар нь хүний эрхийн Монгол Улсын олон улсын гэрээ, хүний эрхийг хамгаалах механизмийн талаар НҮБ-аас өгсөн зөвлөмжид нийцэж байгаа эсэх	Тийм	
	1.3.3.Хүний эрхийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тусгах эсэх		Зөвхөн ГТХ-ийн 31 дүгээр зүйлийн 31.3 дах заалтад өөрчлөлт оруулж байгаа болно	
2.Хүний эрхийг		2.1.Зохицуулалт нь хүний эрхийг хязгаарлах тохиолдолд энэ нь хууль ёсны ашиг сонирхолд нийцсэн эсэх		
		2.2.Хязгаарлалт тогтоох нь зайлшгүй эсэх		
3.Эрх агуулагч[8]		3.1.Зохицуулалтын хувилбарт хамаарах бүлгүүд буюу эрх агуулагчдыг тодорхойлсон эсэх	Тийм	
		3.2.Эрх агуулагчдыг эмзэг байдлаар нь ялгаж тодорхойлсон эсэх	Үгүй	

	3.3.Зохицуулалтын хувилбар нь энэхүү эмзэг бүлгийн нөхцөл байдлыг харгалзан үзэж, тэдний эмзэг байдлыг дээрдүүлэхэд чиглэсэн эсэх	Тийм		
	3.4.Эрх агуулагчдын, ялангуяа эмзэг бүлгийн ялгаатай хэрэгцээг тооцсон мэдрэмжтэй зохицуулалтыг тусгах эсэх (хөгжлийн бэрхшээлтэй, үндэстний цөөнх, хэлний цөөнх, гагцхүү эдгээрээр хязгаарлахгүй)	Тийм		
4.Үүрэг хүлээгч	4.1.Үүрэг хүлээгчдийг тодорхойлсон эсэх	Тийм		
5.Жендэрийн	5.1.Жендэрийн үзэл баримтлалыг тусгасан эсэх	Тийм		
	5.2.Эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагын баталгааг бүрдүүлэх эсэх	Тийм		

Хүснэгт 2: Эдийн засагт үзүүлэх үр нөлөө

Үзүүлэх үр нөлөө		Хариулт	Тайлбар
1.Дэлхийн зах зээл дээр өрсөлдөх чадвар	1.1.Дотоодын аж ахуйн нэгж болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж хоорондын өрсөлдөөнд нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	
	1.2.Хил дамнасан хөрөнгө оруулалтын шилжилт хөдөлгөөнд нөлөө үзүүлэх эсэх (эдийн засгийн байршил өөрчлөгдөхийг оролцуулан)	Үгүй	
	1.3.Дэлхийн зах зээл дээрх таагүй нөлөөллийг монголын зах зээлд орж ирэхээс хамгаалахад нөлөөлж чадах эсэх	Тийм	
2.Дотоодын зах зээлийн өрсөлдөх чадвар болон тогтвортой байдал	2.1.Хэрэглэгчдийн шийдвэр гаргах боломжийг бууруулах эсэх	Үгүй	
	2.2.Хязгаарлагдмал өрсөлдөөний улмаас үнийн хөөрөгдлийг бий болгох эсэх	Үгүй	
	2.3.Зах зээлд шинээр орж ирж байгаа аж ахуйн нэгжид бэрхшээл, хүндрэл бий болгох эсэх	Үгүй	
	2.4.Зах зээлд шинээр монополийг бий болгох эсэх	Үгүй	

3.Аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлийн болон захиргааны зардал	3.1.Зохицуулалтын хувилбарыг хэрэгжүүлснээр аж ахуйн нэгжид шинээр зардал үүсэх эсэх		Үгүй	
	3.2.Санхүүжилтийн эх үүсвэр олж авахад нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	
	3.3.Зах зээлээс тодорхой бараа бүтээгдэхүүнийг худалдан авахад хүргэх эсэх		Үгүй	
	3.4.Бараа бүтээгдэхүүний борлуулалтад ямар нэг хязгаарлалт, эсхүл хориг тавих эсэх		Үгүй	
	3.5.Аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа зогсооход хүргэх эсэх		Үгүй	
4.Мэдээлэх үүргийн улмаас байгаа захиргааны зардлын ачаалал	4.1.Хуулийн этгээдэд захиргааны шинж чанартай нэмэлт зардал (Тухайлбал, мэдээлэх, тайлан гаргах г.м) бий болгох эсэх		Үгүй	
5.Өмчлөх эрх	5.1.Өмчлөх эрхийг (үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгө, эдийн бус баялаг зэргийг) хөндсөн зохицуулалт бий болох эсэх		Үгүй	
	5.2.Өмчлөх эрх олж авах, шилжүүлэх болон хэрэгжүүлэхэд хязгаарлалт бий болгох эсэх		Үгүй	
	5.3.Оюуны өмчийн (патент, барааны тэмдэг, зохиогчийн эрх зэрэг) эрхийг хөндсөн зохицуулалт бий болгох эсэх		Үгүй	
6.Инноваци болон судалгаа шинжилгээ	6.1.Судалгаа шинжилгээ, нээлт хийх, шинэ бүтээл гаргах асуудлыг дэмжих эсэх		Үгүй	
	6.2.Үйлдвэрлэлийн шинэ технологи болон шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх, дэлгэрүүлэхийг илүү хялбар болгох эсэх		Үгүй	
7.Хэрэглэгч болон гэр бүлийн төсөв	7.1.Хэрэглээний үнийн түвшинд нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	
	7.2.Хэрэглэгчдийн хувьд дотоодын зах зээлийг ашиглах боломж олгох эсэх	Тийм		
	7.3.Хэрэглэгчдийн эрх ашигт нөлөөлөх эсэх		Үгүй	
	7.4.Хувь хүний/гэр бүлийн санхүүгийн байдалд (шууд буюу урт хугацааны туршид) нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	

8.Тодорхой бүс нутаг, салбарууд	8.1.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байрыг шинээр бий болгох эсэх		Үгүй	
	8.2.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байр багасгах чиглэлээр нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	
	8.3.Жижиг, дунд үйлдвэр, эсхүл аль нэг салбарт нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	
9.Төрийн захиргааны байгууллага	9.1.Улсын төсөвт нөлөө үзүүлэх эсэх	Тийм		
	9.2.Шинээр төрийн байгууллага байгуулах, эсхүл төрийн байгууллагад бүтцийн өөрчлөлт хийх шаардлага тавигдах эсэх		Үгүй	
	9.3.Төрийн байгууллагад захиргааны шинэ чиг үүрэг бий болгох эсэх		Үгүй	
10.Макро эдийн засгийн хүрээнд	10.1.Эдийн засгийн өсөлт болон ажил эрхлэлтийн байдалд нөлөө үзүүлэх эсэх	Тийм		
	10.2.Хөрөнгө оруулалтын нөхцөлийг сайжруулах, зах зээлийн тогтвортой хөгжлийг дэмжих эсэх	Тийм		
	10.3.Инфляци нэмэгдэх эсэх		Үгүй	
11.Олон улсын харилцаа	11.1.Монгол Улсын олон улсын гэрээтэй нийцэж байгаа эсэх	Тийм		

Хүснэгт 3: Нийгэмд үзүүлэх үр нөлөө

Үзүүлэх үр нөлөө		Хариулт	Тайлбар
1.Ажил эрхлэлтийн байдал, хөдөлмөрийн зах зээл	1.1.Шинээр ажлын байр бий болох эсэх		Үгүй
	1.2.Шууд болон шууд бусаар ажлын байрны цомхотгол бий болгох эсэх		Үгүй
	1.3.Тодорхой ажил мэргэжлийн хүмүүс болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд нөлөө үзүүлэх эсэх		Үгүй
	1.4.Тодорхой насны хүмүүсийн ажил эрхлэлтийн байдалд нөлөөлөх эсэх		Үгүй
2.Ажлын стандарт, хөдөлмөрлөх эрх	2.1.Ажлын чанар, стандартад нөлөөлөх эсэх		Үгүй
	2.2.Ажилчдын эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдалд нөлөөлөх эсэх		Үгүй

	2.3.Ажилчдын эрх, үүрэгт шууд болон шууд бусаар нөлөөлөх эсэх	Үгүй	
	2.4.Шинээр ажлын стандарт гаргах эсэх	Үгүй	
	2.5.Ажлын байранд технологийн шинэчлэлийг хэрэгжүүлэхтэй холбогдсон өөрчлөлт бий болгох эсэх	Үгүй	
3.Нийгмийн тодорхой бүлгийг хамгаалах асуудал	3.1.Шууд болон шууд бусаар тэгш бус байдал үүсгэх эсэх	Үгүй	
	3.2.Тодорхой бүлэг болон хүмүүст сөрөг нөлөө үзүүлэх эсэх. Тухайлбал, эмзэг бүлэг, хөгжлийн бэршээлтэй иргэд, ажилгүй иргэд, үндэстний цөөнхөд гэх мэт	Үгүй	
	3.3.Гадаадын иргэдэд илэрхий нөлөөлөх эсэх	Үгүй	
4.Төрийн удирдлага, сайн засаглал, шүүх эрх мэдэл, хэвлэл мэдээлэл, ёс суртахуун	4.1.Засаглалын харилцаанд оролцогчдод нөлөөлөх эсэх	Үгүй	
	4.2.Төрийн байгууллагуудын үүрэг, үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Үгүй	
	4.3.Төрийн захиргааны албан хаагчдын эрх, үүрэг, харилцаанд нөлөөлөх эсэх	Үгүй	
	4.4.Иргэдийн шүүхэд хандах, асуудлаа шийдвэрлүүлэх эрхэд нөлөөлөх эсэх	Үгүй	
	4.5.Улс төрийн нам, төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Үгүй	
5.Нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал	5.1.Хувь хүн/нийт хүн амын дундаж наслалт, өвчлөлт, нас баралтын байдалд нөлөөлөх эсэх	Үгүй	
	5.2.Зохицуулалтын хувилбарын улмаас үүсэх дуу чимээ, агаар, хөрсний чанарын өөрчлөлт хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	
	5.3.Хүмүүсийн амьдралын хэв маяг (хооллолт, хөдөлгөөн, архи, тамхины хэрэглээ)-т нөлөөлөх эсэх	Үгүй	
6.Нийгмийн хамгаалал, эрүүл мэнд,	6.1.Нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжид нөлөөлөх эсэх	Үгүй	
	6.2.Ажилчдын боловсрол, шилжилт хөдөлгөөнд нөлөөлөх эсэх	Үгүй	

боловсролын систем	6.3.Иргэдийн боловсрол (төрийн болон хувийн хэвшлийн боловсролын байгууллага) олох, мэргэжил эзэмших, давтан сургалтад хамрагдахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	
	6.4.Нийгмийн болон эрүүл мэндийн үйлчилгээ авахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	
	6.5.Их, дээд сургуулиудын үйл ажиллагаа, өөрийн удирдлагад нөлөөлөх эсэх	Үгүй	
7.Гэмт хэрэг, нийгмийн аюулгүй байдал	7.1.Нийгмийн аюулгүй байдал, гэмт хэргийн нөхцөл байдалд нөлөөлөх эсэх	Үгүй	
	7.2.Хуулийг албадан хэрэгжүүлэхэд нөлөөлөх эсэх	Үгүй	
	7.3.Гэмт хэргийн илрүүлэлтэд нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	
	7.4.Гэмт хэргийн хохирогчид, гэрчийн эрхэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	
8.Соёл	8.1.Соёлын өвийг хамгаалахад нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	
	8.2.Хэл, соёлын ялгаатай байдал бий болгох эсэх, эсхүл уг ялгаатай байдалд нөлөөлөх эсэх	Үгүй	
	8.3.Иргэдийн түүх, соёлоо хамгаалах оролцоонд нөлөөлөх эсэх	Үгүй	

Хүснэгт 4: Байгаль орчинд үзүүлэх үр нөлөө

Үзүүлэх нөлөө	Үр	Хариулт	Тайлбар
1.Агаар	1.1.Зохицуулалтын хувилбарын үр дүнд агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Үгүй	
2.Зам тээвэр, түлш, эрчим хүч	2.1.Тээврийн хэрэгслийн түлшний хэрэглээг нэмэгдүүлэх/бууруулах эсэх	Үгүй	
	2.2.Эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэх эсэх	Үгүй	
	2.3.Эрчим хүчний үйлдвэрлэлд нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	
	2.4.Тээврийн хэрэгслийн агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Үгүй	
	3.1.Ан амьтны тоо хэмжээг бууруулах эсэх	Үгүй	

3. Ан амьтан, ургамлыг хамгаалах	3.2. Ховордсон болон нэн ховор амьтан, ургамалд сөргөөр нөлөөлөх эсэх	Үгүй	
	3.3. Ан амьтдын нүүдэл, суурьшилд сөргөөр нөлөөлөх эсэх	Үгүй	
	3.4. Тусгай хамгаалалттай газар нутагт сөргөөр нөлөөлөх эсэх	Үгүй	
4. Усны нөөц	4.1. Газрын дээрх ус болон гүний ус, цэвэр усны нөөцөд сөргөөр нөлөөлөх эсэх	Үгүй	
	4.2. Усны бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Үгүй	
	4.3. Ундны усны чанарт нөлөөлөх эсэх	Үгүй	
5. Хөрсний бохирдол	5.1. Хөрсний бохирдолтод нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	
	5.2. Хөрсийг эвдэх, ашиглагдсан талбайн хэмжээг нэмэгдүүлэх эсэх	Үгүй	
6. Газрын ашиглалт	6.1. Ашиглагдаагүй байсан газрыг ашиглах эсэх	Үгүй	
	6.2. Газрын зориулалтыг өөрчлөх эсэх	Үгүй	
	6.3. Экологийн зориулалтаар хамгаалагдсан газрын зориулалтыг өөрчлөх эсэх	Үгүй	
7. Нөхөн сэргээгдэх/нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялаг	7.1. Нөхөн сэргээгдэх байгалийн баялгийг өөрөө нөхөн сэргээгдэх чадавхийг нь алдагдуулахгүйгээр зохистой ашиглах эсэх	Үгүй	
	7.2. Нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялгийн ашиглалт нэмэгдэх эсэх	Тийм	

Зургаа. Үр дүнг үнэлж, зөвлөмж өгсөн байдал

Байгалийн баялгийг ашиглах төрийн бодлого нь урт хугацааны хөгжлийн бодлогод тулгуурлаж, одоо ба ирээдүй үеийн иргэн бүрт эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг нь баталгаажуулах, газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлж тэгш, шударга хүртээх боломж бүрдэнэ.

Энэхүү тандан судалгааг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор баталсан аргачлалыг удирдлага болгосон.

-----o0o-----

ГАЗРЫН ТОСНЫ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨНИЙ ТАЙЛАН

НЭГ.ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Энэхүү үнэлгээний ажлын зорилго нь Монгол Улсын Их Хурлын гишүүдээс боловсруулсан Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн зүйл, хэсэг, заалтад Хууль тогтоомжийн тухай хуулийн¹ 17 дугаар зүйлд заасны дагуу дүн шинжилгээ хийх, үр нөлөөг тооцож, давхардал, хийдэл, зөрчлийг илрүүлэн, хуулийн төслийн зүйл, заалтыг ойлгомжтой, хэрэгжих боломжтой, хүлээн зөвшөөрөгдөх байдлаар боловсруулахад хууль санаачлагчид дэмжлэг үзүүлэх, улмаар төслийн чанарыг сайжруулахад чиглэсэн дүгнэлт, зөвлөмж өгөхөд оршино.

Үнэлгээ хийхээр сонгож авсан хуулийн төсөл нь хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн хэлбэрээр боловсруулагдсан байна.

Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн /цаашид “хуулийн төсөл” гэх/ үр нөлөөг үнэлэх ажиллагааг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Хуулийн төслийн үр нөлөөг тооцох аргачлал”-д² /цаашид “Аргачлал” гэх/ заасны дагуу дараах үе шаттайгаар хийж гүйцэтгэлээ. Үүнд:

- 1.Шалгуур үзүүлэлтийг сонгох;
- 2.Хуулийн төслөөс үр нөлөө тооцох хэсгээ тогтоох;
- 3.Урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу үр нөлөөг тооцох;
- 4.Үр дүнг үнэлэх, зөвлөмж өгөх.

ХОЁР.ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ, ҮНДЭСЛЭЛ

Энэхүү үнэлгээний ажлыг хийж гүйцэтгэхдээ хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан Аргачлалын 2.9-д³ заасныг үндэслэн дараах 5 шалгуур үзүүлэлтийг сонголоо. Үүнд:

1. Зорилгод хүрэх байдал
2. Практикт хэрэгжих боломж
3. Хүлээн зөвшөөрөгдөх байдал
4. Ойлгомжтой байдал
5. Харилцан уялдаа
6. Зардлын тооцоо

Шалгуур үзүүлэлтийг сонгосон үндэслэл:

- **Зорилгод хүрэх байдал**

¹ <https://www.legalinfo.mn/law/details/11119>

² <https://www.legalinfo.mn/annex/details/7335?lawid=11993>

³ 2.9.... тухайн боловсруулж байгаа хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан нэг, эсхүл хэд хэдэн шалгуур үзүүлэлтийг сонгож болно.

Энэхүү шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зохицуулалт нь анх дэвшүүлсэн зорилго буюу тулгамдсан асуудлыг шийдвэрлэж чадах эсэхийг тогтоох явдал тул төслийн зүйл, хэсэг, заалт хуулийн төслийн үзэл баримтлал буюу хуулийн төслийг боловсруулах болсон үндэслэл, шаардлагад нийцсэн байдал, мөн түүнийг тодорхой илэрхийлж байгаа эсэхийг тогтоох зорилгоор уг шалгуур үзүүлэлтийг сонгосон болно.

- Практикт хэрэгжих боломж

Хуулийн төслийн үзэл баримтлалд тусгагдсан төслийг хэрэгжүүлэх боломж, хуулийн төслийг хэрэгжүүлэх субъектийн чадавх, хуулийн зохицуулалтыг хэрэгжүүлэх бодит боломж, газрын тосны салбарын өмнө тулгарч байгаа өнөөгийн хүндрэлийг даван туулах, түүнээс олсон орлогыг ард иргэдэд оновчтой хэлбэрээр хүртээх хувилбарыг өргөтгөхийг зорилоо.

- Ойлгомжтой байдал

Хуулийн зохицуулалт ойлгомжтой байх нь хэрэгжилтийн үр дүнд шууд нөлөөлдөг. Хууль тогтоомжийн тухай хуульд заасан хуулийн төслийн бүтэц, хэлбэрийн хувьд логик дараалалтай, хэл зүй, найруулгын хувьд тодорхой, ойлгоход энгийн байхаар томъёологдсон байх шаардлагыг хангасан эсэхийг тогтоох зорилгоор уг шалгуур үзүүлэлтийг сонгосон болно.

- Хүлээн зөвшөөрөгдөх байдал

Хуулийн төслийн зохицуулалт иргэд, байгууллагад хэрхэн нөлөөлөх, түүнийг эдгээр этгээд (хуулийн төсөл шууд нөлөөлөх иргэн, хуулийн этгээд) хүлээн зөвшөөрөх эсэхийг шалгана. Өөрөөр хэлбэл, тухайн зохицуулалтаар иргэдийн эрх, эрх чөлөөг хязгаарлаж байгаа эсэх, аж ахуйн нэгжүүдэд шинээр үүрэг хүлээлгэсэн эсэх, эсхүл тухайн хуулийн төслийг хэрэгжүүлэх байгууллагын үйл ажиллагаанд нийцэх эсэхийг шалгаж тогтоохоор энэ үзүүлэлтийг сонгосон болно.

- Харилцан уялдаа

Хуулийн төслийн зүйл, хэсэг, заалт нь хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа бусад хууль тогтоомжид нийцэж байгаа байдал, түүнчлэн төслийн зохицуулалтууд өөр хоорондоо уялдаатай эсэх, давхардал, зөрчилгүй эсэх, хуулийн төслөөр үүрэг хүлээсэн субъектүүдийн чиг үүрэг давхардал, зөрчилгүй томъёологдсон эсэхийг тогтоох буюу Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан агуулгын шаардлагыг хангасан эсэхийг шалгах зорилгоор тус шалгуур үзүүлэлтийг сонгож байна.

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”-ын дагуу хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбоотой гарах зардлын тооцоог тусгайлан гаргасан тул “зардал тооцох” шалгуур үзүүлэлтийг энэхүү тайланд сонгоогүй болно.

**ГУРАВ.ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ХЭСГИЙГ
ТОГТООСОН БАЙДАЛ**

Сонгосон шалгуур үзүүлэлтийн дагуу үр нөлөөг үнэлэхэд шалгах хэрэгслийг дараах байдлаар тогтоолоо.

Хүснэгт 1

Шалгуур үзүүлэлт		Шалгах хэрэгсэл
1	Зорилгод хүрэх байдал	Хуулийн төслийн үзэл баримтлалд дэвшүүлсэн зорилтыг хангах эсэхэд дүн шинжилгээ хийх
2	Практикт хэрэгжих боломж	Хуулийг дагаж мөрдөх, хэрэгжүүлэхэд боломжтой байдлаар тусгасан эсэх, зохицуулалтыг хэрэгжүүлэх байгууллагад хэрэгжүүлэх боломж, нөөц байгаа эсэхийг санал авах, одоогийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийх
3	Хүлээн зөвшөөрөгдөх байдал	Хуулийн төслийн зохицуулалтаар иргэдийн эрх, эрх чөлөөг хязгаарлаж байгаа эсэх, аж ахуйн нэгжүүдэд шинээр үүрэг хүлээлгэсэн эсэх, тухайн хуулийн төслийг хэрэгжүүлэх төрийн байгууллагын үйл ажиллагаанд нийцэх эсэх, чиг үүргийн давхардал үүсэх эсэхийг шалгах
4	Ойлгомжтой байдал	Хууль тогтоомжийн тухай хуулийн 25, 28, 29, 30 дугаар зүйл, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг шалгах
5	Харилцан уялдаа	Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1, 29.1.5, 29.1.7, 29.1.10-т болон Аргачлалын 4.10-т заасан шаардлага, шалгуурыг хангасан эсэхийг шалгах

Дээрх шалгуур үзүүлэлтийн хүрээнд холбогдох зүйл, хэсэг, заалтыг сонгохдоо хууль зүйн хувьд шууд үр дагавар үүсгэж байгаа голлох ач холбогдол бүхий зохицуулалтыг сонгож авлаа. Өөрөөр хэлбэл, шинээр зохицуулалт хийж буй голлох ач холбогдол бүхий заалтыг сонгож үр нөлөөг нь судлах бөгөөд тэдгээр зохицуулалт нь хуулийн төсөл батлагдсанаар тодорхой зардал үүсгэж болохуйц, эсхүл тусгай зөвшөөрөл олгохтой холбоотой, мөн тодорхой субъектэд үүрэг хүлээлгэсэн, тодорхой байгууллагад шинэ чиг үүрэг бий болгосон, түүнчлэн тухайн чиг үүргийг хэрэгжүүлэх зорилгоор шинэ нэгж, байгууллага бий болгох шаардлагатай эсэхэд чиглэсэн байхаар тогтоов.

3.1. Үнэлгээ хийх шалтгаан

Монгол Улсын Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт: “...Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн нийтийн өмч мөн...” гэж заасан.

Мөн “Иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийнхээ хүрээнд газрын хэвлийн баялгийг ашигласнаар байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн талаар мэдэх эрхтэй. Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашиглахдаа байгалийн баялаг ард түмний мэдэлд байх зарчимд нийцүүлэн түүний үр өгөөжийн дийлэнх нь ард түмэнд ногдож байх эрх зүйн үндсийг хуулиар тогтооно” гэж Үндсэн хуульд тусгасан байдаг.

Үүний дагуу Монгол Улсын Засгийн газраас Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг өргөн мэдүүлснийг Улсын Их Хурал хэлэлцэн 2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр баталсан. Тус хуульд заасан баялгийн төрөлжсөн сангуудад хатуу ашигт малтмал, цацраг идэвхит ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, уул уурхайн олборлолт, ашигт малтмалын боловсруулах салбарын хуулийн этгээдийн төрийн эзэмшилд ногдох ногдол ашгийг хуваарилах харилцааг зохицуулж өгсөн.

Цаашид Газрын тосны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулан газрын тос, байгалийн хий, уламжлалт бус газрын тосны нөөц ашигласны төлбөр, роялти зэргийг төсөвт төвлөрүүлж дахин хуваарилахтай холбоотой харилцааг илүү нарийвчлан зохицуулах шаардлага үүсээд байна.

3.2. Үнэлгээ хийх хүрээ

Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай болон дагалдах бусад хуулийн төслийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний хүрээг дараах байдлаар тодорхойллоо. Үүнд:

Хуулийн төсөлд одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Газрын тосны тухай хуулийн 31.3.Нөөц ашигласны төлбөрийн 30 хувийг орон нутгийн хөгжлийн нэгдсэн санд, 70 хувийг улсын төсөвт тус тус төвлөрүүлнэ гэж заасныг “31.3.Нөөц ашигласны төлбөрийн 10 хувийг тухайн тусгай зөвшөөрлийн талбай байрлах сум, дүүргийн төсөвт, 10 хувийг тухайн тусгай зөвшөөрлийн талбай байрлах аймаг, нийслэлийн төсөвт, 10 хувийг тухайн тусгай зөвшөөрлийн талбай байрлах Бүсийн хөгжлийн санд, 10 хувийг Орон нутгийн хөгжлийн нэгдсэн санд, 25 хувийг улсын төсөвт, 35 хувийг Үндэсний баялгийн санд тус тус хуваарилна” гэж тус тус тусгасан.

Мөн тус хуулийн төслийг дагалдуулан Төсвийн тухай хууль, Үндэсний баялгийн сангийн тухай хууль, Татварын ерөнхий хууль, Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулахаар байна.

Ийнхүү хуульд тусгайлан зохицуулаагүй орхигдуулсан хийдэл, хууль хоорондын зөрчлийг арилгаснаар байгалийн баялгаас олсон орлогыг Ирээдүй өв, Хуримтлалын сангаар дамжуулан иргэдэд тэгш, шударга хүртээх Монгол Улсын Үндсэн хуулийн суурь зарчим хангагдах боломж бүрдэнэ.

3.3. Үнэлгээний шалгуур үзүүлэлт:

Байгалийн баялгийг ашиглах төрийн бодлого нь урт хугацааны хөгжлийн бодлогод тулгуурлаж, одоо ба ирээдүй үеийн иргэн бүрд эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг нь баталгаажуулах, газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлж тэгш, шударга хүртээхэд чиглэнэ.

Үүний дагуу Монгол Улсын Засгийн газраас Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг өргөн мэдүүлснийг Улсын Их Хурал хэлэлцэн 2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр баталсан. Тус хуульд заасан баялгийн төрөлжсөн сангуудад хатуу ашигт малтмал, цацраг идэвхит ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, уул уурхайн

олборлолт, ашигт малтмалын боловсруулах салбарын хуулийн этгээдийн төрийн эзэмшилд ногдох ногдол ашгийг хуваарилах харилцааг зохицуулна.

Газрын хэвлийн баялаг газрын тосыг ашиглах явцад тухайн орон нутгийн хүн амын эрүүл, аюулгүйн орчинд амьдрах эрхийг хамгаалах, амьжиргааг нь дэмжих, байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг хамгийн бага байлгах, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээхэд шаардагдах төсөв, хөрөнгийг тухайн орон нутгийн хөгжлийн сан, орон нутгийн төсөвт хуваарилах зарчим олон улс оронд мөрдөгддөг.

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын үед буюу 1991 онд батлагдсан Газрын тосны тухай хуулийг Монгол Улсын Их Хурал 2014 онд шинэчлэн баталсан. Тус хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсэгт “Гэрээлэгч газрын тосны хайгуулын болон ашиглалтын үед тусгай зөвшөөрлийн төлбөрийг жил бүр төлнө.” 30.6 дахь хэсэгт “Тусгай зөвшөөрлийн төлбөрийн 10 хувийг тухайн тусгай зөвшөөрлийн талбайг харьяалах сум, дүүргийн төсөвт, 20 хувийг аймаг, нийслэлийн төсөвт, 70 хувийг улсын төсөвт тус тус хуваарилна” гэж заасан.

Түүнчлэн энэ зүйлийн дараагийн заалт болох Нөөц ашигласны төлбөр, түүний хуваарилалт гэсэн 31 дүгээр зүйлийн 31.3 дэх хэсэгт “Нөөц ашигласны төлбөрийн 30 хувийг тухайн орон нутгийн хөгжлийн нэгдсэн санд, 70 хувийг улсын төсөвт тус тус төвлөрүүлнэ” гэж заасан байсныг 2021 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулж “...тухайн” гэсэн үгийг хассан байна.

Энэ нь хууль тогтоогчийн 2014 онд баталсан хуулийн үзэл баримтлалыг өөрчилж, нөлөөлөлд өртөж буй байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх болон тухайн орон нутгийн иргэдэд байгалийн баялгийн өгөөжөөс тэгш хуваарилах эрх зүйн байдлыг дордуулсан өөрчлөлт болсон гэж үзэхээр байгаа юм.

3.4.Статистик, тоон мэдээ цуглуулсан байдал

Монгол Улс газрын тос боловсруулах үйлдвэр ашиглалтад орох үед дотоодын түүхий тосоор хангах стратегийг баримтлах нь нэн чухал бөгөөд эрэл, хайгуул, ашиглалтын үйл ажиллагааг байгаль орчинд хамгийн бага сөрөг нөлөөлөл үзүүлэх дэвшилтэт технологиор гүйцэтгэх, баялгийн өгөөжийг ард түмэнд шударгаар хуваарилах, олборлолтын нөлөөлөлд өртөж буй тухайн орон нутаг, иргэдэд өгөөжтэй байх учиртай.

Газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулан Дорнод аймгийн Халхгол, Матад сумын нутаг дахь Тосон-Уул XIX, Тамсаг XXI талбайд үйл ажиллагаа явуулж буй БНХАУ-ын хөрөнгө оруулалттай Петрочайна Дачин Тамсаг ХХК, Дорноговь аймгийн Сайншанд сумын нутаг дахь 1997 оны БХГ-т талбайд үйл ажиллагаа явуулж буй БНХАУ-ын хөрөнгө оруулалттай Доншен Газрын тос (Монгол) ХХК-иуд нь 2024 онд нийт 568.7 мянган тонн газрын тос олборлож, 556.3 мянган тонн газрын тос экспортод гаргасан байна.

Газрын тосны борлуулалтын орлогоос 2020 оноос хойш газрын тосны нөөц ашигласны төлбөрт 51.1 сая ам.доллар, Монгол Улсын Засгийн газарт ногдох ашигт тос 269.9 сая ам.доллар буюу, нийт 321.0 сая ам.долларыг Улсын төсөвт төвлөрүүлсэн.

Газрын тосны олборлолт, ашиглалтын тухайд цаашид 2040 он хүртэл жилийн олборлолт 1.5 сая тонн хүртэл өсөх төлөвтэй байна.

Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн практик үр нөлөө:

Газрын тосны тухай хуульд энэхүү өөрчлөлтийг оруулснаар газрын тос, байгалийн хий, уламжлалт бус газрын тосны нөөц ашигласны төлбөр, рояалти зэргийг төсөвт төвлөрүүлж дахин хуваарилахтай холбоотой харилцааг илүү нарийн зохицуулах замаар газрын хэвлийн баялаг газрын тосыг ашиглах явцад тухайн орон нутгийн хүн амын эрүүл, аюулгүйн орчинд амьдрах эрхийг хамгаалах, амьжиргааг нь дэмжих, байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг хамгийн бага байлгах, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээхэд шаардагдах төсөв, хөрөнгийг хуваарилах нөхцөл бүрдэнэ.

Газрын хэвлийн баялаг болох газрын тос, байгалийн хийн нөөц ашигласны төлбөрийн тодорхой хувийг Үндэсний баялгийн төрөлжсэн сан, улс, орон нутгийн төсөв, Орон нутгийн хөгжлийн нэгдсэн болон Бүсийн хөгжлийн сангуудад хуваарилах эрх зүйн орчин бүрдэнэ.

Газрын тос, байгалийн хий олборлох, боловсруулах салбарын төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд дэх төрийн эзэмшлийн ногдох ногдол ашгийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлнэ.

Газрын хэвлийн баялаг газрын тос, байгалийн хийг олборлох, ашиглах явцад сөрөг нөлөөлөлд өртөж буй тухайн бүс, орон нутгийн хүн амын эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах нөхцөл сайжрах зэрэг эерэг нөлөөлөл бий болно.

ДӨРӨВ.ҮР ДҮНГ ҮНЭЛЖ, ЗӨВЛӨМЖ ӨГСӨН БАЙДАЛ

Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үр нөлөөг тооцох дүн шинжилгээ хийх, хянах ажиллагааны үр дүнд гарсан дүгнэлтэд тулгуурлан дараах зөвлөмжийг гарган хүргүүлж байна.

1.Хуулийн төсөлд тусгагдсан материаллаг хэм хэмжээ бүхий зүйл, заалтыг хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлсэн процессын шинжтэй зохицуулалтуудыг тусгахад анхаарахаас гадна хуулийн зохицуулалтын ач холбогдлыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг зөвлөж байна.

2.Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1-д заасан “Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцсэн, бусад хууль, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай уялдсан байх” гэсэн нийтлэг шаардлагын тухайд:

а/Монгол Улсын Үндсэн хууль нийгэм, эдийн засаг, улс төрийн харилцааны үндсийг тогтоож, тус улсын эрх зүйн тогтолцооны суурь болдог тул аливаа хуулийн төслийг юун түрүүн Үндсэн хуульд нийцсэн эсэх шалгуураар авч үздэг. Хуулийн төслийн зохицуулах үндсэн объект нь автотээвэрлэлтийн үйл ажиллагаа, үйлчилгээ эрхлэх, түүнийг зохион байгуулах харилцаа учраас Монгол Улсын Үндсэн хуулийн үндсэн агуулга, холбогдох зохицуулалттай нийцэж байна.

б/Түүнчлэн хуулийн төслийн үзэл баримтлал, зохицуулалт нь Монгол Улсын олон улсын гэрээгээр хүлээсэн үүрэгт үндэслэгдсэн төдийгүй, уг үүргээ хэрэгжүүлэхэд чиглэгдэж байгаа учир чухал ач холбогдолтой гэж үзэж байна.

3.Хуулийн төсөл нь тухайн харилцаанд оролцогчдод ойлгомжтой, логик дараалалтай боловсруулагдсан гэж дүгнэлээ.

4.Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд хавсаргасан үзэл баримтлал нь хуулийг боловсруулах хууль зүйн болон практик үндэслэл, шаардлагыг Монгол Улсын нэгдэн орсон Олон улсын гэрээ, конвенцид үндэслэн тодорхойлж, хуулийн төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээг оновчтой, тодорхой гаргажээ.

5.Төслийн баримт бичигт тавих ерөнхий шаардлагын дагуу уг хууль батлагдсанаар бий болох үр дагавар, түүний ач холбогдлыг тодорхойлсон байна. Хууль батлагдсанаар гарах нийгэм, эдийн засгийн талаарх эерэг нөлөөллийг тодорхойлсноос гадна эрх зүйн орчны хувьд салбарын хуулийн чанар сайжирч, түүний хэрэгжилтийн үр нөлөө дээшилнэ гэж төсөл боловсруулагч үзжээ. Түүнчлэн энэ хуулийг хэрэгжүүлэх зорилгоор цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулиудын талаар ч саналаа дэвшүүлжээ.

Харин төсөл нь 2014 онд баталсан хуулийн үзэл баримтлалыг өөрчилж, нөлөөлөлд өртөж буй байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх болон тухайн орон нутгийн иргэдэд байгалийн баялгийн өгөөжөөс тэгш хуваарилах эрх зүйн байдлыг дордуулах эрсдэл үүсэж болзошгүйг анхаарах шаардлагатай гэж үзлээ.

Бүхэлд нь дүгнэж үзэхэд хуульд өөрчлөлт оруулах энэ төсөл нь хөндвөл зохих асуудлыг хамруулсан, үндэслэл бүхий болсон байна гэж үзлээ.

Энэхүү төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээнд нийцсэн, холбогдох хуулиудтай уялдсан, тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд хамаарах асуудлыг тодорхой түвшинд тусгасан, зохицуулах харилцааны хүрээнээс хальсан асуудлыг тусгаагүй, зүйл, хэсэг, заалт нь хоорондоо агуулгын зөрчилгүй байх зэрэг асуудлыг тусгасан байна.

Иймд уг төсөл Хууль тогтоомжийн тухайн хуулиар тодорхойлсон агуулгын нийтлэг шаардлагыг хангаж байна гэж дүгнэж байна.

-----oOo-----

ГАЗРЫН ТОСНЫ ТУХАЙ ХУУЛЬД ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ЗАРДЛЫН ТООЦООНЫ ТАЙЛАН

Нэг.Ерөнхий мэдээлэл

Хууль тогтоомжийн тухай хууль¹-ийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт “Хууль тогтоомжийн төслийг баталснаар тухайн хууль тогтоомжийн үйлчлэх хүрээнд хамрагдах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд үүсэх зардлын тооцоог тухай бүр гаргаж, зардал, үр өгөөжийн харьцааг энэ хуулийн 12.1.4-т заасан аргачлалын дагуу тодорхойлно.” гэж заасны дагуу Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /цаашид “хуулийн төсөл” гэх/ батлагдсан нөхцөлд түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал /цаашид “аргачлал” гэх/-ын дагуу тооцлоо.

Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хуулийн төслийн үр нөлөөг урьдчилан тандан судлах явцад гүйцэтгэх нь тухайн эрх зүйн зохицуулалтын үр нөлөөгөөр хүрэхийг хүссэн үр дүн, түүнийг хэрэгжүүлэх тогтолцоог бий болгоход зарцуулах зардлын харьцааг тогтооход чухал үүрэг гүйцэтгэдэг. Энэхүү үнэлгээний зорилго нь хуулийн төсөл батлагдсанаар иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагад шинээр үүсэх зардлын ачааллыг урьдчилан тооцож, цаашид гарах зардлыг багасгах санал боловсруулахад оршино.

Хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг тооцоход доор дурдсан нийтлэг зарчмыг баримтлан ажилласан:

- иргэн, төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг нэг бүрийг оновчтой тодорхойлох;²
- үүрэг гүйцэтгэхэд зарцуулах хугацааг тогтооход бодитой хандах;³
- бодит тоо баримт, мэдээлэлд тулгуурлах;⁴
- аргачлалд заасан тооцоо хийх үе шатыг баримтлах.⁵

Аргачлалын Ерөнхий зүйлийн 1.5-д заасан журмын дагуу зардлыг (1) төрийн байгууллагын зардал, (2) хуулийн этгээдийн зардал, (3) иргэнд үүсэх зардал гэсэн гурван төрлөөр тооцдог.

Харин тус хуулийн төсөл батлагдсанаар иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагад зардал үүсгэх зохицуулалт тусгаагдаагүй тул аливаа нэмэлт болон шинэ зардал гарахааргүй байна.

Хоёр.Газрын тосны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл батлагдсанаар хуулийн этгээдэд үүсэх зардлын тооцоо

Энэ хэсэгт хуулийн төсөл батлагдсанаар хуулийн этгээдийн эрхлэх үйл ажиллагаатай холбоотой гүйцэтгэх үүргийн улмаас үүсэх зардлыг мөнгөн дүнгээр

¹ 2015 оны 5 дугаар сарын 29-ний өдөр батлагдаж, тухай бүр нэмэлт, өөрчлөлт орсон Хууль тогтоомжийн тухай Монгол Улсын хууль <https://legalinfo.mn/mn/detail?lawId=11119>

² Аргачлалын 2.3, 4.3 дахь хэсэг

³ Аргачлалын 2.4.4, 4.4 дэх хэсэг

⁴ Аргачлалын 4.4.3.1 дэх дэд заалт

⁵ Аргачлалын 2.1, 4.1 дэх хэсэг

тооцоолно. Ийнхүү үүсэх зардлыг аргачлалын 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсэгт заасны дагуу дараах үе шаттайгаар тооцоолж гаргасан. Үүнд:

- 2.1.хуулийн этгээдийн гүйцэтгэх үүргийг тогтоох;
- 2.2.нэг бүрийн зардлыг тооцох;
- 2.3.тоон үзүүлэлтийг тооцох;
- 2.4.нийт зардлын дүнг тооцож гаргах;
- 2.5.хялбарчлах боломжийг шалгах;
- 2.6.нэмэлт зардлыг тооцох.

Хуулийн төсөлд хуулийн этгээдэд шинээр үүрэг хүлээлгэсэн, зардал бий болгосон зохицуулалт байхгүй байна.

Гурав.Газрын тосны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл батлагдсанаар иргэнд үүсэх зардлын тооцоо

Хуулийн төсөл батлагдсанаар иргэнд үүсэх зардлыг аргачлалын 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт заасны дагуу дараах дарааллыг баримтлан тогтооно. Үүнд:

- 3.1.иргэний гүйцэтгэх үүргийг тогтоох;
- 3.2.цаг хугацаа болон гарч болох зардлыг тооцох;
- 3.3.тоон үзүүлэлтийг тооцох;
- 3.4.нийт дүнг тооцож гаргах;
- 3.5.хялбарчлах боломжийг шалгах.

Газрын тосны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тусгагдсан иргэнд шинээр гүйцэтгэх үүрэг хүлээлгэсэн, зардал бий болгох зохицуулалт байхгүй байна.

Дөрөв.Газрын тосны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл батлагдсанаар улсын төсөвт үүсэх зардлын тооцоо

Аргачлалын 4.1-д зааснаар Төрийн байгууллагын зардал буюу улсын төсөвт үүсэх ачааллыг тооцохын тулд тухайн ажил үйлчилгээг гүйцэтгэхэд шаардагдах хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлж, түүнд шаардагдах зардлыг тооцож гаргах бөгөөд уг ажлыг дараах үе шаттайгаар зохион байгуулна:

- 4.1.төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг буюу ажил, үйлчилгээг тодорхойлох;
- 4.2.уг чиг үүргийг гүйцэтгэх хүний нөөцийг тодорхойлох;
- 4.3.гарах зардлыг урьдчилан тооцох;
- 4.4.зардлыг нэгтгэн тооцох;
- 4.5.хувилбарыг нягталж, үр дүнг танилцуулахаар тогтоосон.

Хуулийн төсөлд төрийн байгууллагад шинэ чиг үүрэг нэмэгдүүлсэн зохицуулалт тусгаагүй тул төсөвт шинээр зардал үүсэхгүй болно.

ИРГЭД ОЛОН НИЙТИЙН САНАЛ, ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН ТУХАЙ ТАНИЛЦУУЛГА

Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх олон нийтийн хэлэлцүүлгийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.6.4-т заасны дагуу цахим хэлбэрээр явуулахаар 2025 оны 06 дугаар сарын 19-ний өдөр d.parliament.mn цахим хуудсанд байршуулж, санал авах ажлыг зохион байгуулан ажилласан.

2026 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн байдлаар тус хуулийн төсөлд 3 санал, дэмжлэг ирүүлсэн байна. Үүнд:

Д/д	Нэр	Ирүүлсэн санал	Хуулийн төсөлд тусгасан эсэх
1	Баттулгуур	1 дүгээр зүйл 31.3 дахь хэсэгт (Дэмжиж байна)	✓
2	Алтансүх	1 дүгээр зүйл 31.3 дахь хэсэгт (Бүрэн дэмжиж байна)	✓
3	Нямсүрэн	1 дүгээр зүйл 31.3 дахь хэсэгт(Үндэсний баялгийн сангаас гадна улсын төсөвт тодорхой хувийг хуваарилдаг байх хэрэгтэй.	✓

Хууль тогтоомжийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.10 дахь хэсэгт зааснаар “Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөх иргэн, хуулийн этгээдийн төлөөллөөс санал авч, хууль тогтоомжийн төслийн бүрдүүлбэрт хавсаргах” асуудал уг хуулийн төслөөр энэ асуудлыг Сангийн яам хариуцан ажиллах тул Засгийн газрын санал дүгнэлтэд болон хуулийн төслийг өргөн мэдүүлэхэд Сангийн яам зөвшөөрөл өгдөг тул тусад нь санал авах шаардлагагүй болно.

Хууль санаачлагч нар



УИХ-ын гишүүн
Мягмарсүрэнгийн БАДАМС...



УИХ-ын гишүүн
Шинэбаярын БЯМБАСҮРЭН



УИХ-ын гишүүн
Гомбын ГАНБААТАР



УИХ-ын гишүүн
Мөнгөнцогийн ГАНХҮЛЭГ



УИХ-ын гишүүн
Борхүүгийн ДЭЛГЭРСАЙХАН

Боловсруулж буй



Өргөн баригдсан



Хэлэлцэх эсэх



Ажлын хэсэг



Анхны хэлэлцүүлэг



Эцсийн хэлэлцүүлэг



Батлах



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 ОНЫ 6-Р САРЫН 19 ӨДӨР

УЛААНБААТАР

ГАЗРЫН ТОСНЫ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 ДУГААР ЗҮЙЛ

31 ЭНЭЦЭШ

2 ДУГААР ЗҮЙЛ

X

1 дүгээр зүйл. Газрын тосны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3 дахь хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай.



Санал бичих

Б

БАГТУЛУУР
Дэмжиж байна

Хариулах 2025.07.07 122.201.31.216

А

АЛТАНСҮХ
бүрэн дэмжиж байна

Хариулах 2025.07.07 66.181.161.223

Н

НЯМСҮРЭН
Үндэсний баялагын сангаас гадна улсын төсөвт тодорхой хувийг хуваарилдаг байх хэрэгтэй. Бүсчилсэн хөгжлийн сан байгуулна гэж ойлгох уу. Одоогоор энэ сан байдаггүй.

Хариулах 2025.07.06 66.181.186.159



УИХ-ын гишүүн
ГОНЦОГИЙН ГАНХУЛЭГ



УИХ-ын гишүүн
БОРХУУГИЙН ДЭЛГЭРСАЙХААН

ЦУУЛЭГ

Эцсийн хэлэлцүүлэг

Батлах

УЛААНБААТАР

АХ ТУХАЙ



1 дүгээр зүйл. Газр

"31.3.Нөөц аши

дсанаар өөрчлөн найруулсугай.

рлах сум, дүүргийн төсөвт, 10 хувийг тухайн

✓ Дэлэх